

Хос соёлт сурагчдын эцэг
эхчүүдэд зориулсан элсэлтийн
гарын авлага

Хүүхдээ сургуульд явуулах



Солонгосын сургуулийн боловсрол

Солонгосын боловсролын систем

The educational system of the Republic of Korea consists of



Сургалтын хугацаа болон хамрагдах нас

| Хөтөлбөр | Хөтөлбөрийн нэр | Сурах хугацаа | Хамрагдах нас | Тайлбар |
|-----------------------|-----------------|---------------|-----------------|---|
| Цэцэрлэгийн боловсрол | Цэцэрлэг | 3 | 3~5 нас | |
| Бага ангийн боловсрол | Бага сургууль | 6 | 6~11 нас | Ерөнхий боловсрол, төлбөргүй боловсрол* |
| Дунд ангийн боловсрол | Дунд сургууль | 3 | 12~14 нас | Ерөнхий боловсрол, төлбөргүй боловсрол* |
| | Ахлах сургууль | 3 | 15~17 нас | Төлбөргүй боловсрол* |
| Дээд боловсрол | Коллеж | 4 | 18 наснаас дээш | |

* Төлбөргүй боловсролтой холбоотой дэмжлэг: Элсэлтийн төлбөр, сургалтын төлбөр, сургуулийн үйл ажиллагааг дэмжих төлбөр, сурах бичиг худалдан авах төлбөр

* Хүүхдээ ерөнхий боловсрол эзэмшүүлэхгүй байх тохиолдолд торгууль ногдуулж болно

* Зөвхөн хувийн бага сургууль, хувийн дунд сургууль, бие даасан хэлбэрийн хувийн ахлах сургууль, зарим хувийн тусгай мэргэжлийн ахлах сургууль, тусгай сургууль(урлаг, биеийн тамир, олон улсын сургууль гэх мэт)-ийн сургалтын зардлыг хариуцна

Солонгосын сургуулийн амьдрал

Солонгосын ихэнх сургуулиудын хичээлийн шинэ жил 3-р сарын эхний ажлын өдөр эхэлдэг бөгөөд сургуулийн төрөл ангиллаас хамаарч зохион байгуулах арга хэмжээ нь өөр өөр байдаг.



Жилд зохиогдох боловсролын гол чухал арга хэмжээ, үйл ажиллагаа

| Арга хэмжээний нэр | Агуулга | Зохиогдох хугацаа |
|---|--|-------------------------------------|
| Элсэлтийн ёслол (Нээлтийн ёслол) | Хичээлийн шинэ жил, шинэ улирал эхлэх өдөр | 3-р сарын эхний ажлын өдөр |
| Дурын амралтын өдөр | Сургуулиас тогтоосон амардаг өдөр | Сургуулиас тогтооно |
| Сургуулийн ойн баярын өдөр | Сургууль байгуулагдсаныг тэмдэглэх өдөр | Сургуулиас тогтооно |
| Туршлага судлах бодит сургалт | Музей, фермийн туршлага судлах зэрэг гадуур хичээллэх өдөр | 4 дүгээр сар, 10 дугаар сар |
| Биеийн тамирын өдөрлөг (спортын тэмцээн уралдаан) | Сургуулийн нийт сурагчдын болон ангийн ангиллаар зохион явуулах спортын тэмцээн уралдааны өдөр | 5 дугаар сар |
| Нээлттэй хичээлийн өдөр | Сургуулийн хичээлийг нээлттэй явуулах өдөр | 4~5 дугаар сар |
| Зуны амралт | Эхний улирал дууссаны дараа зуны амралт эхлэх өдөр | 7 дугаар сарын сүүл |
| Зуны хичээлийн жилийн нээлтийн ёслол | Зуны амралт дууссаны дараа 2 дугаар улирлын хичээл эхлэх өдөр | 8 дугаар сарын сүүл |
| Өвлийн амралт | Өвлийн амралт эхлэх өдөр | 12 дугаар сарын сүүл ~ 1 дүгээр сар |
| Хаалтын ёслол (Төгсөлтийн баяр) | Тухайн хичээлийн жил дуусах өдөр | 1~2 дугаар сар |



Хичээлийн хуваарь: (бага анги 40 минут, дунд анги 45 минут, ахлах анги 50 минут) ба завсарлагааны цаг(10 минут).

| Хичээлийн цаг | Цаг | Үйл ажиллагаа |
|-----------------|-------------|---|
| 1-р цаг | 09:10~09:50 | Хичээл |
| 2-р цаг | 10:00~10:40 | Хичээл |
| 3-р цаг | 10:50~11:30 | Хичээл |
| 4-р цаг | 11:40~12:20 | Хичээл |
| Үдийн цайны цаг | 12:20~13:10 | Үдийн цай, чөлөөт цаг |
| 5-р цаг | 13:10~13:50 | Хичээл |
| 6-р цаг | 14:00~14:40 | Хичээл |
| Дараа | 14:00~16:30 | Асрамжийн анги, нэмэлт хичээл (зөвхөн оролцохыг хүссэн хүн) |

* Дээрх хуваарь нь бага сургуулийн жишээ бөгөөд сургуулийн ангилал, сургууль бүрт эхлэх цаг, хичээлийн цаг нь өөр өөр байдаг.

Хос соёлт сурагчдад зориулсан Солонгос сургуулийн боловсрол

Сурч боловсрох тэгш шударга боломжоор хангах зорилгоор албан боловсролд хамруулах дэмжлэг

- Хүүхэд, өсвөр насныхан оршин суух зөвшөөрөл, харьяалал, арьс өнгө зэргээсээ үл хамааран бага, дунд сургуульд элсэх, шилжин суралцах, сургуулиасаа гараад өөр сургуульд орох боломжтой.
- Эцэг, эх нь нийгмийн статусаа бусдад мэдэгдэхээс санаа зовж хүүхдээ сургуульд явуулахгүй байх тохиолдол байдаг боловч хүүхдийнх нь сурч боловсрох эрхийг хамгаалах зорилгоор гадаад иргэний бүртгэлд хамрагдалгүй удаан хугацаагаар оршин сууж буй эцэг эхийг хянаж журамладаггүй.

Сургуулийн боловсролын бэлтгэлийн дэмжлэг



Холбогч хөтөлбөр

Бага, дунд сургуульд элсэн орох, шилжин суралцах гэж буй хос соёлт сурагчдын хамрагдах сургуулийн амьдралын эхэн үед дасан зохицоход туслах хөтөлбөр.

Тохируулсан хэлбэрийн солонгос хэлний сургалт, хичээл сургалтын дэмжлэг



Солонгос хэлний анги болон солонгос хэлний ганцаарчилсан сургалт

Солонгост ирээд удаагүй, хичээлийн жил эхэлсний дараа солонгост ирсэн болон гадаад сурагч зэрэг хос соёлт сурагчдад зориулсан солонгос хэлний эрчимжүүлсэн боловсрол олгох тусгай анги ажиллуулдаг.



Оюутны зөвлөгөө хөтөлбөр

Их сургуулийн оюутан(зөвлөгч) хос соёлт бага насны хүүхэд болон сурагч(зөвлөгөө авагч)-дад сургуулийн амьдралд дасан зохицох, суралцахад нь дэмжлэг үзүүлдэг.



Сургалтын туслах материалын боловсруулалт, хангалт

Хос соёлт сурагчдын сурах үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалтын үндсэн ойлголт, үгсийн санг ойлгоход хялбар байдлаар тайлбарласан сурах бичиг

Мэргэжил сонгох боловсрол, сэтгэл санааны дэмжлэг



Хос хэл эзэмшихийн давуу талыг хөгжүүлэх дэмжлэг

Хос соёлт сурагчдын хос хэл эзэмших үйлсийг дэмжих зорилгоор хос хэл дээрх сурах бичгийг цахим ном хэлбэрээр боловсруулж, “Улсын хэмжээний хос хэлээр ярих уралдаан”-ыг зохион байгуулдаг.



Мэргэжил сонгох боловсролын хөтөлбөр ба зөвлөх арга хэмжээ

Цагаач эцэг эхтэй өсвөр үеийнхний онцлогт тохируулсан сурагчдын мэргэжил сонгох боловсролын хөтөлбөр ба “Видеогаар явуулах алсын зайн мэргэжил сонгох зөвлөгөө(mentoring.career.go.kr)” арга хэмжээг явуулдаг.



Сургуулийн амьдрал, сэтгэл санааны дэмжлэг

Олон хэлний хувилбар бүхий “Сэтгэл санаа, үйл хөдлөлийн онцлогийн судалгааны хуудас” өгч, тухайн дүүргийн хос соёлт хүүхэд өсвөр үеийнхнийг дэмжих байгууллагатай холбож өгдөг.



I. Элсэлтийн бэлтгэл

1. Элсэлтийн бэлтгэлийн журам 5
2. Гадаад сурагч сургуульд элсэхэд бүрдүүлэх материал 6



II. Сургуульд элсэх журам

1. Цэцэрлэгийн элсэлт 7
2. Бага сургуулийн элсэлт 8
3. Дунд сургуулийн элсэлт 10
4. Ахлах сургуулийн элсэлт 12



III. Сургуулийн боловсролын дэмжлэг

1. Сургуулийн боловсролын бэлтгэлийн дэмжлэг 13
2. Тухайн сурагчид тохируулсан солонгос хэлний сургалт болон хичээл сургалтын дэмжлэг 13
3. Мэргэжил сонгох боловсрол, сэтгэл санааны дэмжлэг 14



IV. Боловсролыг дэмжих систем

1. Сургалтын зардлын дэмжлэг 15
2. Сургууль, амьдралын дэмжлэг 17

[Хавсралт 1] Сургууль(цэцэрлэг)-ийн амьдралтай холбоотой нэр томъёо 18

[Хавсралт 2] «Солонгосын боловсролын систем ба анги дэвших мэдээлэл»
Эцэг эхчүүдэд зориулсан видео гарын авлага 22

[Хавсралт 3] Солонгос хэлний үнэ төлбөргүй онлайн сургалтын сайтын танилцуулга 23



I

Элсэлтийн бэлтгэл

1. Элсэлтийн бэлтгэлийн журам



БНСУ-ын иргэншилтэй

БНСУ-ын иргэншлийг оруулаад давхар иргэншилтэй тохиолдолд хамаарна

Хос соёлт бус сурагчидтай адил журмыг дагаж мөрдөнө



Цэцэрлэг

- “Анхны сургуульдаа (www.go-firstschool.go.kr)” цахим хуудсаар дамжуулан өргөдөл гаргах болон сонгон шалгаруулна (10-11-р сар сургуулийн өмнөх насны хүүхэд элсүүлэх хугацаа)
- Элсэхийг хүсэж буй цэцэрлэгийнхээ захиралд элсэх хүсэлт гаргана
- ※ Элсүүлэх орон тооны хүрээнд элсэх боломжтой



Бага сургууль

- Засаг захиргааны байгууллагаас сургуульд элсэх мэдэгдлийг гэрээрээ хүлээн авах



Дунд сургууль

- Сурч байгаа бага сургуулийн зүгээс сургуульд элсэх өргөдөл гаргаж, дунд сургуульд хуваарилна
- ※ Тусгай дунд сургуулийн хувьд сургуулийн цахим хуудаснаас элсэлтийн сонгон шалгаруулалтын талаар тусгайлан үзэх шаардлагатай



Ахлах сургууль

- Сурч байгаа дунд сургуулийн зүгээс сургуульд элсэх өргөдөл гаргаж, ахлах сургуульд хуваарилна
- ※ “Ахлах сургуулийн элсэлтийн мэдээллийн портал (www.hischool.go.kr)” цахим хуудаснаас тусгайлан үзэх шаардлагатай



Гадаад иргэншилтэй

Бичиг баримтгүй цагаач хүүхдүүд, дүрвэгсэд багтана

Гадаад сурагчдын хувийн хэргийн хяналтын журмыг дагаж мөрдөнө

- Элсэхийг хүсэж буй цэцэрлэгийнхээ захиралд элсэх хүсэлт гаргана
- ※ Элсүүлэх орон тооны хүрээнд элсэх боломжтой

- Өөрийн оршин суугаа газрыг хариуцдаг дүүргийн* бага сургуулийн захиралд элсэх хүсэлтээ гаргана
- ※ Боловсролын газраас лавлаж шалгана уу

- Оршин суугаа газрын харьяалагдах Боловсролыг дэмжих газарт эсвэл дунд сургуулийн захиралд элсэх хүсэлт гаргана

- Элсэхийг хүсэж буй ахлах сургуулийнхаа захиралд элсэх хүсэлт гаргана



Дээрх журам нь Солонгос улсад анх удаа сургуульд орж буй хос соёлт сурагчдад зориулагдсан бөгөөд хүүхдээ элсүүлэх, шилжин суралцуулах сургуулийг сонгохдоо эхлээд өөрийн оршин суугаа газрыг хариуцдаг дүүрэгт байрлах сургууль эсвэл Боловсролын (дэмжих) газар, Хос соёл боловсролыг дэмжих төв зэрэг байгууллагаас лавлаж зөвлөгөө авах шаардалагатай.

Элсэлттэй холбоотой нэр томъёо



Элсэлт : Сургуульд орох (1-р ангид шинээр элсэн орох)

Сургуульд элсэх : Анх удаа ерөнхий боловсролын сургуулийн тохирох ангид орох

Шилжин суралцах: Ерөнхий боловсролд хамрагдах үүрэггүй бөгөөд сургуулиасаа гарсан хүн буцаад сургуульдаа ороод сурч байхдаа дээд ангид дахин элсэн орох юмуу өөр сургуульд дахин элсэн орох (Ерөнхий боловсрол хамрагдах үүрэггүй хүн сургуулиасаа гарсны дараа өмнөхтэйгөө адил анги эсвэл доод түвшний бага, дунд сургуулийн ангид дахин элсэн орох тохиолдолд ч шилжин суралцаж байгаад тооцно)

2. Гадаадын иргэншилтэй сурагчийн элсэлтийн бүрдүүлэх материал

| | | | |
|----|--|---|--|
| 01 | Сургуульд элсэх, шилжин суралцах өргөдөл | <ul style="list-style-type: none"> Элсэх гэж буй сургууль эсвэл Боловсролын газраас өгсөн маягт | <input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 02 | Хилээр нэвтэрсэн тодорхойлолт эсвэл гадаад иргэний бүртгэлийн тодорхойлолт | <ul style="list-style-type: none"> Түрээсийн гэрээ, оршин сууж буйг батлах баталгаа гэх мэт оршин суугаа нь үнэн болохыг тодорхойлох материалаар орлуулах боломжтой Тухайн хүн зөвшөөрсөн тохиолдолд сургууль, Боловсролыг дэмжих газраас иргэний бүртгэлийн хуулбар, хураангуй тойм, гадаад иргэний бүртгэлийн тодорхойлолт зэргийг бичгээр авалгүй цахимаар лавлан үзэх боломжтой | <input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 03 | Дүнгийн тодорхойлолт | <ul style="list-style-type: none"> Сургууль төгссөн юмуу сурч буй анги хүртэлх дүнгийн агуулгыг нотлох материал | <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 04 | Сургуульд сурч буй тодорхойлолт, төгсөлтийн гэрчилгээ (хамаарах хүн) | <ul style="list-style-type: none"> Хичээлийн жил, сургуульд элссэн, гарсан огноо болон сурч буй ангийг тодорхойлох сургуулийн захирлын гарын үсэг(тамга)-тэй материал | <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 05 | Сурагчийн хувийн хэрэг (хамаарах хүн) | <ul style="list-style-type: none"> Солонгост сургуульд сурч байсан бол бүрдүүлнэ | <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 06 | Вакцинжуулалтын гэрчилгээ | <ul style="list-style-type: none"> “Сурагчийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хямралын үед авах арга хэмжээний гарын авлага”-д заасан “Гадаадаас шилжин ирж буй сурагчийн вакцинжуулалтын хяналт”-ын дагуу сургуулийн зүгээс холбогдох материалыг шаардаж болно. | <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 07 | Хот, аймгийн боловсролын газрын удирдамжид дурдсан бусад материал | <ul style="list-style-type: none"> Зайлшгүй харьяалагдах Боловсролын газрын материалыг лавлан үзэх шаардлагаатай | <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |
| 08 | | <ul style="list-style-type: none"> Үүнээс гадна зарим сургуулийн зүгээс боловсролын зорилгоор сурагчийн мэдээллийг шалгахын тулд паспортын хуулбар, ам бүлийн тодорхойлолт, иргэний бүртгэлийн хуулбар (БНСУ-ын иргэншил авсан тохиолдолд) зэрэг материалыг шаардаж болно. | <input type="checkbox"/> Цэцэрлэг <input type="checkbox"/> бага <input type="checkbox"/> дунд <input type="checkbox"/> ахлах сургууль |



- Боловсролын яамны “Гадаад дахь магадлан итгэмжлэгдсэн бага, дунд, ахлах сургуулиудын жагсаалт”-ад орсон тохиолдолд апостиль гэрчилгээ юмуу гадаад дахь консулын газрын тодорхойлолтгүйгээр зөвхөн сургуулийн захирлын олгосон материалаар орлуулж болно.
- Үүнээс бусад гадаадын сургуулиас олгосон материалд “Апостиль гэрчилгээ”(Апостиль конвенцийн гишүүн улс) юмуу БНСУ-ын гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрын “Консулын тодорхойлолт” авах шаардлагатай.
* Хүсэлт гаргагч нь тухайн улсын албан ёсны боловсролын байгууллага гэдгийг тайлбарлах (оршин суугаа улсын харьяалагдах Боловсролын газраас магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын жагсаалт зэргийг хэвлэн авч ирүүлэх гэх мэт) юмуу эсвэл дээр дурдсаны адилаар “Апостиль гэрчилгээ”(Апостиль конвенцийн гишүүн улс) юмуу БНСУ-ын гадаад дахь дипломат төлөөлөгчийн газрын “Консулын тодорхойлолт” авах шаардлагатай.
- Боловсролын түвшинг нотлох материал нь сургуулийн захирлын албан тамга, гарын үсэг эсвэл тамга тэмдэгтэй байна.
- Солонгос, англиас өөр хэлээр бичигдсэн боловсролын түвшинг нотлох материалд нотариатаар баталгаажуулсан орчуулгыг хавсаргана.
- Бүрдүүлсэн материалыг хуурамчаар үйлдсэн юмуу засварласан нь илэрвэл тухайн сурагчийн элсэлтийг цуцалж болно.



Боловсролын түвшинг нотлоход хэцүү тохиолдолд “Хос соёлт сурагчдын боловсролын түвшинг хэлэлцэх хороо” боловсролын түвшинг хүлээн зөвшөөрөх, анги түвшин тогтоохтой холбоотой асуудлыг хэлэлцэнэ



II

Сургуульд орох



1. Цэцэрлэгт элсэн орох



Төрөл

Улсын цэцэрлэг

Улсаас байгуулж, ажиллуулдаг цэцэрлэг

Улсын цэцэрлэг

Орон нутгийн бие даасан байгууллагаас байгуулж, ажиллуулдаг хот/аймгийн цэцэрлэг

Хувийн цэцэрлэг

Хуулийн этгээд юмуу хувь хүний үүсгэн байгуулж, ажиллуулдаг цэцэрлэг



Элсэлтэд хамрагдагч болон элсэх хугацаа

- Бага сургуульд орохын өмнөх 3-5 нас хүрсэн хүүхдүүд цэцэрлэгт элсэн орно
- 10~11 дүгээр сард "Анхны сургуульдаа" цахим хуудсаар элсэх хүсэлтээ гаргах бөгөөд бусад үед насны ангиллаар орон тоог харгалзан үзэж үе үе элсэлт авах боломжтой



Элсэх журам

Цэцэрлэгт элсэх хүсэлт гаргахаас эхлээд бүртгэл хүртэлх бүх үйл ажиллагааг цэцэрлэгийн элсэлтийн хянах систем болох "Анхны сургуульдаа" цахим хуудас(www.go-firstschool.go.kr)-аар дамжуулан явуулна.

Нэн тэргүүний элсэлт*

Өргөдөл хүлээн авах
Сугалаа сугалах, зарлах
Бүртгэх

Ердийн элсэлт

Урьдчилан бүртгүүлэх
Үндсэн бүртгэл хийх
Сугалаа сугалж зарлах
Бүртгэх
Хүлээлгийн хяналт

Нэмэлт элсэлт

Бүртгэл

* Нэн тэргүүний элсэлт*

- Нэн тэргүүний элсэлтэд хамрагдах боломжтой эсэхээ цэцэрлэгийн элсэлтийн зарчмаас лавлан үзнэ үү
- Нэн тэргүүний элсэлтэд хамрагдагч нь нотлох материалаа тухайн цэцэрлэгт зайлшгүй бүрдүүлж өгөн шалгуулах ёстой

- "Анхны сургуульдаа" цахим хуудсаар дамжуулан явагддаг элсэлтийн хугацаанаас бусад үед элсэх хүсэлтээ цэцэрлэгт шууд гаргаж өгөх бөгөөд насны ангиллаар орон тоо гүйцээгүй тохиолдолд элсэж орох боломжтой.



"Анхны сургуульдаа" цахим хуудсыг ашиглах журам



Сургалтын зохион байгуулалт, үйл ажиллагаа

- Өдөр тутмын үйл ажиллагаа: Сургалтын хөтөлбөр (өдөрт 4-5 цаг) болон хичээлээс гадуур хөтөлбөр(сургалтын хөтөлбөрийн дараа) хэлбэрээр явагдах бөгөөд цэцэрлэг бүрийн үйл ажиллагаа явуулах цаг өөр байж болно

Хичээлийн хуваарийн жишээ

| Төрөл | Цаг | Үйл ажиллагааны агуулга |
|---------------------------|-------------|--|
| Сургалтын хөтөлбөр | 09:00~13:00 | Цэцэрлэгтээ ирэх, чөлөөтэй тоглох, хөнгөн цай уух, гадаа тоглох, үдийн хоол идэх, үйл ажиллагаанд оролцох |
| Хичээлээс гадуур хөтөлбөр | 13:00~18:00 | Амрах болон өдөр унтах, үдээс хойш хөнгөн цай уух, тусгай хөтөлбөрт оролцох Онцлогт үйл ажиллагаанд оролцох, чөлөөтэй тоглох, гадаа тоглох |



2. Бага сургуульд элсэн орох



Сургуулийн төрөл

Улсын бага сургууль

Улсаас байгуулж, ажиллуулдаг бага сургууль, боловсролын их сургууль, улсын их сургууль, багшийн дээд сургуулийн харьяа бага сургууль

Улсын бага сургууль

Орон нутгийн бие даасан байгууллагаас байгуулж, ажиллуулдаг хот/аймгийн бага сургууль

Хувийн бага сургууль

Хуулийн этгээд юмуу хувь хүний үүсгэн байгуулж, ажиллуулдаг бага сургууль



Элсэлтэд хамрагдагч болон элсэх хугацаа

- Дараа жилийн 3-р сарын 1-нд 6 нас хүрсэн өдрөөс эхлэн бага сургуульд элсэх ёстой бөгөөд бага анги заавал хамрагдах ёстой, үнэ төлбөргүй боловсрол юм. Хэрэв эцэг эхчүүд хүүхдээ сургуульд оруулахгүй бол торгууль ногдуулж болно.



Элсэх журам

Солонгосын бага сургуулийн элсэлт дараах журмаар явагдана



- Ер нь хүүхдийг оршин суугаа газрынх нь харьяалагдах сургуульд оруулдаг боловч хос соёлт гэр бүлийн хүүхдүүдийн хувьд тэдэнд зориулсан тусгай анги (солонгос хэлний анги) бүхий бага сургуульд элсэх боломжтой.
- Сургуульд эрт орох эсвэл хойшлуулах хүсэлтэй эцэг эхчүүд жил бүрийн 10-р сарын 1-нээс 12-р сарын 31-ний хооронд харьяалагдах хороо, сумын захиргаа юмуу хорооны иргэдийн бие даасан төвд очиж хүсэлтээ гаргана.
- * Сургуульд эрт орох эсвэл хойшлуулах тохиолдолд эцэг эхийн сонголтоор шийдэгддэг тул хүсэлт гаргахаасаа өмнө нухацтай бодоод шийдвэр гаргах шаардлагатай.



Хос соёлт сурагчид бага ангид элсэн орох

- Гадаад иргэдийн хүүхдүүд Солонгост төрсөн ч сургуулийн элсэлтийн мэдэгдэл өгдөггүй тул өөрт ойр байрлах бага сургуульд Солонгост оршин сууж байгаагаа нотлох материалтайгаа очин элсэлтийн зөвлөгөө авах шаардлагатай.
- Бичиг баримтгүй цагаач хүүхдүүд ч сургуульд элсэх боломжтой бөгөөд орон сууцны түрээсийн гэрээ, батлан даалтын бичиг зэрэг оршин сууж байгааг батлах материал, төрсөн оныг батлах материалыг бүрдүүлэх шаардлагатай.



Сургуулийн амьдралын хөтөч



Хичээл

- **Хичээлийн цаг:** Өдөрт 4 эсвэл 5 хичээл / хичээлийн цаг 40 минут
- **Зохион байгуулах үйл ажиллагаа:** Хичээл сургалт, бүтээлч практик арга хэмжээ

Хичээл сургалт

1~2 дугаар анги | Солонгос хэл, математик, нийлмэл хичээлүүд (Зөв амьдрал, ухаалаг амьдрал, баяр хөөртэй амьдрал)

3~4 дүгээр анги | Солонгос хэл, ёс зүй, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, биеийн тамир, хөгжим, урлаг, англи хэл

5~6 дугаар анги | Солонгос хэл, ёс зүй, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, практик хичээл, биеийн тамир, хөгжим, урлаг, англи хэл

Бүтээлч практик арга хэмжээ

Нийгмийн амьдралд зайлшгүй шаардлагатай амьдралын үндсэн хэв маягийг төлөвшүүлж, хувь хүний онцлог, авьяас чадварыг нээн илрүүлдэг, хичээлээс гадуур арга хэмжээ тул тусдаа сурах бичиг байхгүй



Хичээлээс гадуур хөтөлбөр

- Сургуулийн төлөвлөгөөний дагуу тодорхой хугацаанд тасралтгүй явагддаг байнгын хичээлээс гадуурх сургуулийн боловсролын үйл ажиллагаа
 - **Хамрагдагч:** Тухайн сургуулийн оролцох хүсэлтэй сурагчид
 - **Байршил:** Сургууль болон олон нийтийн янз бүрийн байгууламжууд
 - **Ажиллах хугацаа, цаг:** Сургууль хичээллэх хугацаанд хичээл тарсны дараа(Бямба гариг юмуу хичээлийн амралтын хугацаанд ажиллах боломжтой)
 - **Хөтөлбөр:** Сургалтын хөтөлбөр, авьяас чадварыг нь хөгжүүлэх. Орон нутгийн иргэдтэй уялдан холбогдох, боловсролын хандивын үйл ажиллагаа гэх мэт.
 - **Сургалтын менежмент:** Сурагчдад сурах үйл явц, үр дүнгээр хангах, эцэг эхийн үзэж танилцах хичээлийг явуулна
- * Хөтөлбөр болон ажиллах цагийг нь сургууль бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тогтоодог. Хичээлийн улирлын эхэнд танилцуулах хуудас тараахад хөтөлбөр тус бүрийн хичээлийн төлбөр, явагдах цаг, дэмжлэг авах боломжтой эсэх зэргийг шалгаад өөрийн хүссэн хичээлд бүртгүүлнэ (хүсэлт гаргах арга нь сургуулиас хамаарч өөр өөр байдаг)



Бага сургуулийн асрамжийн анги

- Бага сургуулийн хичээл гадуур хөтөлбөрийн танхимд бага ангийн сурагчдыг асрах үйл ажиллагаа
 - **Хамрагдагч:** Эцэг эх нь хоёулаа ажилладаг, бага орлоготой, өрх толгойлсон гэр бүл зэрэг асран халамжлах шаардлагатай гэр бүлийн хүүхэд
 - **Ажиллуулах байгууллага:** Асрамжийн анги ажиллуулдаг бага сургууль
 - **Дэмжлэг тусламжийн агуулга:** Ганцаараа оролцох үйл ажиллагаа(бичих, унших гэх мэт), хамт олноороо оролцох үйл ажиллагаа(авьяас хөгжүүлэх хөтөлбөр гэх мэт)
- * Ажиллах цаг, хүсэлт гаргах арга нь сургуулийн нөхцөл ба хэрэгцээнээс хамаарч өөр өөр байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг бага сургуулийн асрамжийн анги ажиллуулдаг сургууль эсвэл Засгийн газар 24(www.gov.kr) цахим хуудаснаас авах боломжтой.



3. Дунд сургуульд элсэн орох

Дунд сургуулийн төрөл

Улсын дунд сургууль

Орон нутгийн бие даасан байгууллагаас байгуулж, удирдаж ажиллуулдаг дунд сургууль

Хувийн дунд сургууль

Хувь хүн, хуулийн этгээдийн үүсгэн байгуулж, удирдаж, ажиллуулдаг дунд сургууль

Тусгай дунд сургууль

Олон улсын дунд сургууль
Олон улсын чиглэлээр мэргэшсэн дунд сургууль

Урлаг, биеийн тамирын дунд сургууль
Урлаг, биеийн тамирын чиглэлээр мэргэшсэн дунд сургууль

Сайжруулсан дунд сургууль
Практик голлосон сургалт зэрэг сайжруулсан сургалтын чиглэлээр мэргэшсэн дунд сургууль

Элсэлтэд хамрагдагч

- Үүнтэй дүйцэхүйц боловсролтой гэж хүлээн зөвшөөрөгдсөн хос соёлт гэр бүлийн хүүхдүүд дунд сургуульд суралцах үүрэгтэй.

Элсэлтийн хугацаа


- Дунд сургуулийн элсэлт нь ерөнхийдөө 3-р сард болдог бөгөөд сургуулийн сургалтын хөтөлбөрийг дүүргэхэд саадгүй байх хүрээнд үе үе элсэлт авах боломжтой.
- Тусгай дунд сургуулийн элсэлтийн хугацаа болон элсэлтийн сонгон шалгаруулалт зэрэг нь хот, аймгийн Боловсролын газар бүрт өөр өөр байдаг тул лавласны дараа хүсэлтээ гаргана уу.

Дунд сургуульд элсэх журам





Дунд сургуулийн амьдрал



- ☑ Дунд сургуулийн хувьд бага сургуулийн 6-р ангийн 2 дахь улирал(10-р сар)-д хуваарилагдахыг хүсэж буй дунд сургуулиа сонгоод, эцэг эх нь дунд сургуульд хуваарилагдах өргөдөл бичиж ирүүлнэ.
- ☑ Дунд сургуулийг бүс нутаг, сургуулийн дүүргийн ангиллаар сугалаагаар хуваарилдаг ба хэт алслагдмал зам тээвэр муутай дүүргийн хувьд Боловсролын ажилтны тогтоосон бүсийн хүрээнд элсэн орох сургуулийг хуваарилдаг.
- ☑ **Хос соёлт гэр бүлийн хүүхдүүдийн хувьд тусгай анги бүхий дунд сургуульд элсэх боломжтой.**



Анги

Бага сургуулийн хувьд нэг багш бүх хичээлийг заадаг системтэй байдаг ч дунд сургуулийн хувьд **[анги удирдсан багш + хичээлийн багшийн систем]**-ээр хичээллэдэг.

- **Хичээлийн цаг:** Хичээлийн 6 цаг юмуу 7 цаг (45 минутаар хичээллэнэ)
- **Дүн тооцох:** Цаасаар ирүүлсэн үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээг дүнд тусгана.
 - ※ "Чөлөөт улирал"-д завсрын болон төгсөлтийн шалгалт гэх мэт цаасан дээр суурилсан үнэлгээ тавьдаггүй, харин сурагчийн сурлага, өсөлтийг дэмжих хөтөлбөрт чиглэсэн үнэлгээ тавьдаг.
- **Сургалтын хөтөлбөр:** Хичээл(чиглэлээр ангилсан) + бүтээлч практик арга хэмжээ

Хичээл сургалт (чиглэлээр ангилсан)

Солонгос хэл, нийгэм судлал(түүх орсон)/ёс зүй, математик, шинжлэх ухаан/технологи, гэр бүл/мэдээлэл, биеийн тамир, урлаг (хөгжим/дүрслэх урлаг), англи хэл, сонгон суралцах хичээл(ханз үсэг, байгаль орчин, ахуйн хэрэглээний гадаад хэл, эрүүл мэнд, мэргэжил сонголт, ажил мэргэжил гэх мэт)

Бүтээлч практик арга хэмжээ

Бие даасан үйл ажиллагаа, бүлгэмийн үйл ажиллагаа, сайн дурын үйлчлэл, мэргэжил сонгох арга хэмжээ



Чөлөөт улирлын систем

- Дунд сургуульд нэг юмуу хоёр улирлын хугацаанд мэдлэг өрсөлдөөнөөс ангижирсан, сурагчдын авъяас, дасан зохицох чадварыг хөгжүүлэх, янз бүрийн практик үйл ажиллагаанд төвлөрсөн сургалтын хөтөлбөр явуулдаг систем
- ※ **Чөлөөт улирлын үйл ажиллагаа:** Мэргэжил сонгох эрэл хайгуул, сэдэв сонгох үйл ажиллагаа, бүлгэмийн үйл ажиллагаа, урлаг, спортын үйл ажиллагаа



4. Ахлах сургуульд элсэн орох



Ахлах сургуулийн төрөл

| | | | | | | |
|--|--|--|---|--|--|---|
| Энгийн ахлах сургууль | Ахлах сургуулийн төрлүүдийн хамгийн их хувийг бүрдүүлдэг энгийн ахлах сургууль | | | | | |
| Нарийвчилсан төрөл | Дунд сургуулийн боловсролын суурь дээр дунд түвшний сургалт явуулна | | | | | |
| Элсэлтийн сонгон шалгаруулалт | Ижилсэлттэй дүүрэг: Хувийн хэрэг дээрх дүнгээр сонгон шалгаруулсны дараа сугалаа сугалан хуваарилна Ижилсэлтгүй дүүрэг: Хувийн хэрэг дээрх дүн зэргээр сургууль тус бүрт сурагчийг сонгон шалгаруулна | | | | | |
| Тусгай зорилго бүхий ахлах сургууль | Тусгай салбарын мэргэжлийн боловсрол олгох зорилготой ахлах сургууль | | | | | |
| Нарийвчилсан төрөл | Гадаад хэлний ахлах сургууль Гадаад хэлтэй чадварлаг боловсон хүчин бэлтгэх | Олон улсын ахлах сургууль Олон улсын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх | Шинжлэх ухааны ахлах сургууль Шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэх | Урлагийн ахлах сургууль Уран бүтээлч бэлтгэх | Биеийн тамирын ахлах сургууль Биеийн тамирын ажилтан бэлтгэх | Аж үйлдвэрийн хэрэгцээнд тохируулсан ахлах сургууль (Мейстер ахлах сургууль) Аж үйлдвэрийн салбарын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн сургалтын хөтөлбөр явуулна |
| Элсэлтийн сонгон шалгаруулалт | Бие даан суралцах сонгон шалгаруулалт(хувийн хэрэг дээрх дүн, ярилцлага гэх мэт)-аар сургууль тус бүрт сонгон шалгаруулна | | | Хувийн хэрэг, ярилцлага зэрэг аргаар сургууль тус бүрт сонгон шалгаруулна | | |
| Тусгай ахлах сургууль | Мэргэжлийн төрөлжсөн ахлах сургууль Авьяас, дасан зохицох чадвар, ур чадвараар ойролцоо сурагчдад зориулсан тодорхой салбарын боловсон хүчин бэлтгэх зорилготой сургалт Сайжруулсан хөтөлбөр бүхий тусгай ахлах сургууль байгалийн үзэгдлийн дадлага, зэрэг практик голлосон сургалтыг мэргэжлийн түвшинд явуулдаг ахлах сургууль | | | | | |
| Нарийвчилсан төрөл | Мэргэжлийн төрөлжсөн тусгай ахлах сургууль Сургуулиа төгсөөд ажилд орох хүсэлтэй сурагчдад мэргэжлийн сургалт явуулна | | | Сайжруулсан хөтөлбөр бүхий тусгай ахлах сургууль Сурагчдад төвтэй бие даасан сайжруулсан сургалтын хөтөлбөр явуулна | | |
| Элсэлтийн сонгон шалгаруулалт | Хувийн хэрэг, ярилцлага зэрэг аргаар сургууль тус бүрт сонгон шалгаруулна | | | | | |
| Бие даасан ахлах сургууль | Сургууль эсвэл сургалтын хөтөлбөрийг харьцангуй бие даасан байдлаар явуулах боломжтой ахлах сургууль | | | | | |
| Нарийвчилсан төрөл | Бие даасан хувийн ахлах сургууль Сургуулийг үүсгэн байгуулсан үзэл баримтлалын дагуу сургууль болон сургалтын хөтөлбөрийг бие даасан байдлаар явуулна | | | Бие даасан улсын ахлах сургууль Сургууль болон сургалтын хөтөлбөрийг бие даасан байдлаар явуулна | | |
| Элсэлтийн сонгон шалгаруулалт | Сүүл дүүрэг: 1-р шатанд сугалаа сугалах, 2-р шатанд ярилцлаганд орох * Хана ахлах сургуульд хамаарахгүй Бусад бүс нутаг: Бие даан суралцах сонгон шалгаруулалт(хувийн хэрэг дээрх дүн, ярилцлага гэх мэт)-аар сургууль тус бүрт сонгон шалгаруулна | | | Ижилсэлттэй дүүрэг: Хувийн хэрэг дээрх дүнгээр сонгон шалгаруулсны дараа сугалаа сугалан хуваарилна Ижилсэлтгүй дүүрэг: Хувийн хэрэг дээрх дүн зэргээр сургууль тус бүрт сурагчийг сонгон шалгаруулна | | |

* Дэлгэрэнгүй мэдээллийг "Ахлах сургуулийн элсэлтийн мэдээллийн портал (www.hischool.go.kr)" болон "Тусгай ахлах сургууль/Мейстер ахлах сургуулийн портал (www.hifive.go.kr)"-аас авах боломжтой.



Элсэлтэд хамрагдагч

Дунд сургууль төгссөн эсвэл түүнтэй дүйцэх боловсролтой нь хүлээн зөвшөөрөгдсөн хос соёлт гэр бүлийн хүүхдүүд ахлах сургуульд элсэх боломжтой.



Сонгон шалгаруулалт ба элсэлтийн хугацаа

- Хот, аймгийн Боловсролын газар тус бүрийн "Ахлах сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалтын үндсэн төлөвлөгөө"-өөс дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой (4-р сараас эхлэн харьяалагдах хот, аймгийн Боловсролын газрын цахим хуудсаар дамжуулан авах боломжтой)
- Ахлах сургуулийн хувьд нэг болон хоёрдугаар улиралд хувааж шинэ сурагчдыг сонгон шалгаруулдаг.

Нэгдүгээр улирал

Ердийн ахлах сургууль (урлаг/биеийн тамирын салбар), тусгай зорилго бүхий ахлах сургууль (шинжлэх ухаан/урлаг/биеийн тамирын салбар, аж үйлдвэрлэлийн хэрэгцээнд тохируулсан ахлах сургууль)

Хоёрдугаар улирал

Ердийн ахлах сургууль (урлаг, биеийн тамирын салбараас бусад), тусгай зорилго бүхий ахлах сургууль (гадаад хэл/олон улсын салбар), бие даасан ахлах сургууль (улсын /хувийн) гэх мэт нэгдүгээр улиралд ороогүй үлдсэн бусад сургууль.

- Элсэлтийн хугацаа, элсэлтийн сонгон шалгаруулалт зэрэг нь хот, аймгийн Боловсролын газар болгон өөр өөр байдаг тул лавлан үзээд хүсэлтээ гаргана уу.



III

Сургуулийн боловсролын ДЭМЖЛЭГ

1. Сургуулийн боловсролын бэлтгэлийн дэмжлэг



Холбогч хөтөлбөр
(Хот аймгийн Боловсролын газар)

- Бага, дунд сургуульд элсэн орох гэж буй хос соёлт гэр бүлийн хүүхдүүд сургуулийн амьдралын эхэн үед дасан зохицоход туслах зорилготой бэлтгэл сургалтын хөтөлбөр.



Хөтөлбөрийг явуулах сургуулийг жил бүр тогтоодог.

Бага сургууль

Амьдрал, сургалтын чиглэлээр сургалтын агуулгыг зохион явуулдаг

Дунд сургууль

Үе тэнгийнхний соёлд суурилсан харилцааны бус, туршлага ба үйл ажиллагаанд суурилсан сургуулийн амьдралын бүсээс бүрдсэн хөтөлбөрийг явуулдаг

2. Тохируулсан хэлбэрийн солонгос хэлний сургалт, хичээл сургалтын дэмжлэг



Солонгос хэлний хичээл болон солонгос хэлний ганцаарчилсан сургалт
(Хот, аймгийн Боловсролын газар)

- Солонгост ирээд удаагүй, хичээлийн жил эхэлсний дараа солонгост ирсэн болон гадаад сурагчдад зориулсан солонгос хэлний эрчимжүүлсэн сургалттай тусгай ангийг байгуулан ажиллуулж, солонгос хэлний ангигүй сургуульд хичээлийн жил эхэлсний дараа солонгост ирсэн болон гадаад сурагч шилжиж ирэх юмуу элсэн орох тохиолдолд "Солонгос хэлний ганцаарчилсан сургалт"-ыг зохион байгуулна.

Цэцэрлэг

Солонгос хэлээр харилцахад бэрхшээлтэй гадаад бага насны хүүхдүүд олноор байвал сургалтын хөтөлбөртэй холбосон тоглоом голлосон солонгос хэлний сургалтыг эрчимтэй явуулна.

Бага, дунд анги

Солонгос хэл, соёлын эрчимжүүлсэн сургалтад зориулсан ангийг тусад нь нээж, ганцаарчилсан "Солонгос хэлний (KSL) сургалтын хөтөлбөр" зохион байгуулна.



Оюутны зөвлөгөө хөтөлбөр
(Хот, аймгийн Боловсролын газар, Солонгосын тэтгэлгийн сан)


- Их сургуулийн оюутан(зөвлөгч) хос соёлт бага насны хүүхэд болон сурагч(зөвлөгөө авагч) нарт сургуулийн амьдралд дасан зохицох, суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хичээл сургалт, сэтгэл зүй, сэтгэл мэдрэмжийн талаар ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйл ажиллагаа



Сургалтын туслах материалын боловсруулалт, хангалт
(Хос соёлт боловсролын төв)

- Хос соёлт сурагчдын сурах үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалтын үндсэн ойлголт, үгсийн санг ойлгоход хялбар байдлаар тайлбарласан сурах бичиг бөгөөд QR код, видео контент гэх мэт төрөл бүрийн мэдээллийн хэрэгслээр хангана.

3. Мэргэжил сонгох боловсрол, сэтгэл санааны дэмжлэг



- Хос соёлт сурагчдын хос хэл эзэмших үйлсийг дэмжих зорилгоор хос хэл дээрх сурах бичгийг цахим ном хэлбэрээр боловсруулж, вэб хуудас болон аппликэшнээр дамжуулан хүргэнэ.
- Хос соёлт сурагчдын хос хэл эзэмших үйлсийг дэмжиж, бахархал төрүүлэх зорилгоор "Улсын хэмжээний хос хэлээр ярих уралдаан"-ыг зохион байгуулна.



- Хос соёлт сурагчдын онцлогт нийцүүлсэн мэргэжил сонгох боловсролын хөтөлбөр явуулна.

01

[Career Net Мэргэжил сонгох зөвлөгөө]
– Хос соёлт сурагчдад нийцүүлэн нарийн зөвлөгөө өгөх боломжтой.


02

[Career Net Мэргэжил сонгох видео бичлэг]
– Ажил мэргэжил эрж хайх "Онцгой гойд" хөтөлбөрт гарсан солонгосын янз бүрийн салбарт ажилладаг хос соёлт мэргэжилтнүүдийг танилцуулдаг бичлэгийг олон хэл(хятад, вьетнам)-ний хадмал орчуулгатайгаар хүргэж байна.

03

Эцэг эхчүүдэд зориулсан мэргэжил сонгох мэдээллийн "Мөрөөдлийн захидал" товхимлыг олон хэл(англи, хятад, вьетнам, орос)-ээр гаргаж байна (parenter.go.kr (Эцэг эх Он нүри)-аас унших боломжтой)

- Солонгост ажиллаж амьдардаг солонгосын иргэншил авсан гадаад иргэдийн дундаас мэргэжилтэн гэх зэрэг шилдэг чадварлаг хүнийг зөвлөгчөөр сонгон авч, зөвхөн хос соёлт сурагчдаар зогсохгүй бүх сурагч хамтдаа оролцох боломжтой "Видеогоор явуулах алсын зайн мэргэжил сонгох зөвлөгөө(mentoring.career.go.kr)" арга хэмжээг явуулна.

 Хот аймаг тус бүр өөртөө тохирсон мэргэжил сонгох зусланг ажиллуулдаг тул тухайн хот аймгаас тусгайлан асууж лавлана уу.



- Олон хэлний хувилбар(10 хэл: англи, хятад, япон, вьетнам, филиппин, орос, монгол, араб, кхмер, тайланд) бүхий "Сэтгэл санаа, үйл хөдлөлийн онцлогийн судалгааны хуудас"-ны тусламжтайгаар хос соёлт сурагчдын сэтгэл санаа, үйл хөдлөлийн хөгжлийг дэмжинэ.
- Орон нутаг дахь хос соёлт сурагчдыг дэмжих байгууллагуудтай холбоо тогтоон, сургуульд байхдаа сэтгэл санааны дэмжлэг хэрэгтэй байдаг сурагчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.



IV

Боловсролыг дэмжих систем

1. Сургалтын зардлын дэмжлэг



Бага насны хүүхдийн сургалтын зардлын дэмжлэг



2022.3.1-ний өдрийн байдлаар




Дэмжлэгийн хэмжээ нь хот, аймаг тус бүр өөр байж болох тул дэлгэрэнгүй мэдээллийг оршин суугаа газар юмуу Иргэдэд үйлчлэх төвөөс авна уу.

- Цэцэрлэгт явдаг 3-5 насны бүх хүүхдэд орлогын түвшнээс үл хамааран сургалтын төлбөрийг олгоно. Гэхдээ энэхүү дэмжлэгийг зөвхөн бага сургуульд орохын өмнөх 3 жилийн хугацаанд үзүүлнэ.
 - * Гадаадын иргэншилтэй бага насны хүүхдүүд тэтгэлэг авах боломжгүй (Зөвхөн "Солонгос улс дахь гадаадын иргэдэд нийцүүлсэн үндсэн хууль"-ийн дагуу Хууль зүйн яамны сайдын хүлээн зөвшөөрсөн "Онцгой хувь нэмэр оруулсан хүн гэх мэт" тохиолдолд тусгайд нь авч үзэж тэтгэлэг олгоно)
- Бага насны хүүхдийн сургалтын төлбөрийн дэмжлэг авах шаардлагыг* хангахын зэрэгцээ хуулийн дагуу бага орлоготой өрх(амьжиргааны доод түвшний орлоготой өрх, бага орлоготой өрх, өрх толгойлсон гэр бүл)-ийн хүүхдэд сард 150,000 вон хүртэлх хэмжээний нэмэлт дэмжлэг үзүүлнэ.
 - * Түрүүлж элсэн орсон болон элсэлтээ хойшлуулсан гэх зэрэг бусад дэмжлэг авагчийг багтаасан болно
- Эцэг эх(асран хамгаалагч)-ийн оршин суугаа газрын хорооны Иргэдэд үйлчлэх төвд очих юмуу "Бокжиро" цахим хуудас(www.bokjiro.go.kr)-аар хүсэлтээ гаргах боломжтой.



Бага орлоготой өрхийн хүүхдүүдийн сургалтын зардал, сургалтын тэтгэлгийн дэмжлэг

Бага орлоготой өрхийн хүүхдүүдэд зориулсан ахлах сургуулийн сургалтын төлбөр, сургуулийн хоолны төлбөр зэрэг “сургалтын зардал” ба боловсролын үйл ажиллагааг дэмжих зардал зэргийг олгодог “Сургалтын тэтгэлэг”-ийн систем байдаг бөгөөд эцэг эх(асран хамгаалагч)-ийн оршин суугаа газрын хорооны Иргэдэд үйлчлэх төвд очин хүсэлт гаргах боломжтой.



Лавлах газрууд

Эрүүл мэнд, халамжийн зөвлөгөө өгөх төв **129**
 Сургалтын зардлын ерөнхий зөвлөгөө өгөх төв **1544-9654**
 Тосгон, баг, хорооны Иргэдэд үйлчлэх төвүүд, сургууль, Боловсролын газар

2. Сургууль, амьдралын дэмжлэг



Вии(Wee) анги
(Сургуулийн зөвлөгөө
өгөх танхим) хөтөлбөр

- Вии(Wee) анги бол сургуулийн зөвлөгөө өгөх танхим бөгөөд сургуульдаа дасаагүй болон хямралд орсон сурагчид, зөвлөгөө авах шаардлагатай сурагчдад оношилгоо-зөвлөгөө-эмчилгээний тусламж гэсэн нэгдсэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлснээр гэр болон сургуулийн амьдралдаа дасан зохицох, нийгэмд саадгүй дасан зохицоход нь туслах зорилготой ажилладаг. Мөн сурагчдад тулгарч буй танин мэдэхүй, сэтгэл санаа, үйл хөдлөлийн асуудлуудаа зөв ойлгож, шийдэхэд нь тусалдаг.



Вии(Wee) ангигүй сургуулиудын хувьд Вии(Wee) төвийн эргэлтийн зөвлөгөө өгөх арга хэмжээнд хамрагдах хүсэлт гаргана. (Мэргэжлийн зөвлөх багш байнга байдаг, сэтгэл зүй болон сэтгэл мэдрэмжийн хувьд бэрхшээл тулгарвал Вии ангид зочилно уу, зөвлөгөө авах боломжтой)



Хос соёлт гэр бүлийг
дэмжих төв

- Хос соёлт гэр бүлийг дэмжих төв нь хос соёлт гэр бүлд солонгосын нийгэмд дасан зохицоход нь туслах зорилгоор гэр бүл доторх харилцааг сайжруулах сургалт(гэр бүл, жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх гэх мэт), солонгос хэлний сургалт, айлчлан заах сургалт, зөвлөгөө өгөх, мэдээлэл танилцуулах, гэрлэлтээр ирсэн цагаач иргэдэд аман болон бичгийн орчуулга хийж өгөх, хүүхдийн хэлний хөгжлийг дэмжих зэрэг үйлчилгээг үзүүлдэг байгууллага бөгөөд улсын хэмжээнд 228 газар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.



Цагаач эцэг эхтэй өсвөр
үеийнхнийг дэмжих сангийн
Солонго өсвөр үеийнхний
төв

- Тус төв нь цагаач эцэг эхтэй өсвөр үеийнхэн(Хойд Солонгосоос дүрвэгчид, гадаадад төрөөд Солонгост ирсэн, хос соёлт гэр бүлийн өсвөр насны хүүхэд)-д дэмжлэг үзүүлдэг мэргэжлийн байгууллага бөгөөд тэдгээр хүүхдүүдэд солонгосын нийгэмд дасан зохицох, сурах чадвар болон бие даах чадвараа сайжруулахад нь туслах зорилгоор тэдэнд солонгосын нийгмийн талаарх үндсэн мэдээллийг өгч, солонгос хэлний сургалт, нийгмийн харилцааг сайжруулах хөтөлбөр зэргийг явуулдаг.



Сөүл Он Дрим сургалтын
төв

- Тус төв гадаадад төрөөд солонгост ирсэн боловсролын хувьд анхаарлын гадна байдаг хүүхдүүдийн солонгосын амьдралд дасан зохицоход нь тулгардаг бэрхшээлийг арилгах зорилгоор солонгос хэл заах, мэргэжил сонгох болон ажилд ороход нь туслах сургалт явуулах зэрэг тэдэнд тохируулсан сургалт явуулж тогтвортой дасан зохицоход нь тусалж дэмждэг.



Солонгос хэлний сургалт, солонгосын нийгмийн тухай ойлголт, төрөлжсөн үйлчилгээ (иргэншил солиход бэлдэх анги, ажилд орох чиг баримжаа олгох анги, шалгалтанд бэлтгэх анги, дунд ба ахлах анги, их дээд сургуульд элсэхэд бэлтгэх анги гэх мэт), соёлын туршлага судлах, зөвлөгч, зөвлөгөө өгөх үйлчилгээ гэх мэт.



Данури лавлах төв



1577-1366

- Солонгост оршин сууж буй хос соёлт гэр бүл, цагаач эмэгтэйчүүдэд солонгосын амьдрал ахуйн мэдээлэл өгөх, хямралын үед зөвлөгөө өгөх, яаралтай тусламж үзүүлэх, ахуйн орчуулга болон утасны гурвалсан холбоо үйлчилгээ
- Цагаач эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэшсэн зөвлөхтэй утсаар ярьж төрөлх хэлээрээ зөвлөгөө авах боломжтой. /7 улсын хэл дээр/

* Бүх зөвлөгөө ярилцлага нь зарчмын хувьд нууц бөгөөд тухайн хүний хувийн мэдээллийг задруулахгүй.

Дэмжлэгийн
агуулга

- Яаралтай нүүлгэн шилжүүлэх байгууламж ажиллуулна
- Яаралтай нөхцөл байдал болон хүчирхийллийн хохирогчдод зөвлөгөө өгөх, яаралтай тусламж үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулна
- Амьдрал ахуйн мэдээллээр хангана
- Ахуйн орчуулга болон утасны гурвалсан холбоо үйлчилгээ(Солонгосын өмгөөлөгчдийн холбоотой холбогдож хууль зүйн зөвлөгөө өгөх)



Хавсралт 1 Сургууль(цэцэрлэг)-ийн амьдралтай холбоотой нэр томьёо

* Доорх нэр томьёог бүс нутаг, сургууль (байгууллага) -аас хамааран өөр өөр нэр томьёогоор ашиглаж болно.



Нийтлэг нэр томьёо

| Нэр томьёо | Гол агуулга | Тайлбар |
|--------------------------------------|--|----------------------|
| Захиргааны алба | Сургалтын зардал, практик үйл ажиллагааны зардал зэрэг сургууль(цэцэрлэг)-ийн санхүүгийн орлого, зардалтай холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг газар | |
| Сургуулийн банк (CSM) | (Сургуулийн банк) Эцэг эхийн төлөх ёстой сургалтын зардал(бодит газар дээр нь очиж хийх сургалт гэх мэт)-ыг эцэг эхийн банкны данснаас сургууль(цэцэрлэг)-ийн данс руу автоматаар шилжүүлдэг систем | |
| Элсэлтийн ёслол | Сургууль(цэцэрлэг)-д шинээр элсэн орж буй сурагчдад зориулсан арга хэмжээ | |
| Эцэг эх | Сурагч(бага насны хүүхэд)-ын аав, ээж гэх мэт асран хамгаалагчийг хэлдэг нэр томьёо | |
| Эцэг эх зөвлөгөө авах | Эцэг эх ангийн багшаас сурагч(бага насны хүүхэд)-ын сургууль(цэцэрлэг) дахь амьдралын талаар сонирхож байгаа зүйлээ асуух юмуу асуудлыг шийдэх зорилгоор уулзах ганцаарчилсан уулзалт. | |
| Эцэг эхэд нээлттэй хичээл | Эцэг эхийг сургууль(цэцэрлэг)-д урьж, хичээлийг нээлттэй явуулах арга хэмжээ | |
| Гэр бүлтэй харилцах захидал | Сургууль(цэцэрлэг)-ийн зүгээс эцэг эхчүүдэд сургалтын үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн арга хэмжээ, мэдээлэл зэргийг мэдүүлэх мэдэгдэл | |
| Амралт | Хичээлийн улирал юмуу хичээлийн жилийн эцэст сургууль (цэцэрлэг)-ийн хичээлийг тодорхой хугацаагаар түр зогсоохыг хэлэх ба халууны улиралд зуны амралт, хүйтний улиралд өвлийн амралт зохион байгуулна(Зуны амралт, өвлийн амралт, жилийн эцсийн амралт гэх мэт) | |
| Хичээлийн жилийн нээлтийн ёслол | Сургууль(цэцэрлэг)-ийн амралт дуусаж, дахин байнгын хичээл эхлэх арга хэмжээ | |
| Төгсөлтийн ёслол | Сурагч(бага насны хүүхэд) дүрэм журмын дагуу тогтоосон сургалтын хөтөлбөрийг дуусгасны дараа төгсөлтийн гэрчилгээ гардан авах арга хэмжээ | Цэцэрлэгийг оруулаад |
| Хүнс хангалт | Сургууль(цэцэрлэг)-ийн сурагч(бага насны хүүхэд)-ийг үдийн хоолоор хангах ажил | |
| Хичээлээс гадуур хөтөлбөр | Албан ёсны хичээлийн цагийн дараа явуулдаг бусад сургалтын үйл ажиллагаа, сургууль(цэцэрлэг)-иас зохион байгуулдаг хүүхэд асрах үйл ажиллагааг бүхэлд нь хэлнэ. | |
| Хичээлээс гадуур хөтөлбөрийн багш | Хичээлээс гадуур хөтөлбөрийн хичээлийг явуулж, заадаг багш | |
| Туршлага судлах бодит сургалт | Сургууль(цэцэрлэг)-ийн сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сурагчид газар дээр нь шууд зочилж, амьд туршлагаас биеэрээ суралцах боломж олгодог сургалтын үйл ажиллагаа (Жишээ нь: Анги бүрийн ангиллаар туршлага судлах бодит сургалт явуулах, шаазан эдлэл хийх туршлага, фермийн туршлага гэх мэт) | |
| Сургуулиас гадуурх бодит сургалт | Хувийн төлөвлөгөөний дагуу сургуулийн захирлаас урьдчилан зөвшөөрөл авсны дараа явагддаг туршлага судлах сургалт бөгөөд газар дээр нь очиж үзэх, соёлын туршлага, ажил мэргэжлийн туршлага зэрэг шууд туршлага дээр төвлөрсөн сургалтын үйл ажиллагаа (Жишээ нь: Соёлын аялал, итгэмжилсэн сургалт, гэр бүлийн аялал, хамаатан садандаа зочлох, ачлах ёсны туршлага гэх мэт) | |
| Биеийн тамирын өдөрлөг | Сургууль(цэцэрлэг)-ийн сурагч(бага насны хүүхэд) олноороо цугларч янз бүрийн биеийн тамирын тэмцээн явуулдаг үйл ажиллагаа | |
| Сургуулийн ойн(нээлтийн) баярын өдөр | Сургууль(цэцэрлэг) болгон жил бүр сургууль байгуулагдсан өдрийг тэмдэглэх өдөр | |
| Дурын амралтын өдөр | Сургууль(цэцэрлэг) бие даан амралтын өдрийг тогтоож, сурагчид нэг өдөр эсвэл тодорхой хугацаанд сургуульд очиж хичээл хийхгүй байх өдрүүд | |



| Нэр томьёо | Гол агуулга | Тайлбар |
|--|--|------------------------|
| Эцэг эхийн хурал | Эцэг эхчүүд цугларан сургууль бүрийн сургалтын үйл ажиллагаатай танилцаж, сургуулийн менежментийн талаар ярилцах уулзалт(Сургалтын үйл явцын тайлбар хуралдаан) | |
| Багшийн ур чадварыг хөгжүүлэх үнэлгээ (Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа) | Сургууль(цэцэрлэг)-ийн багш, хичээлийн эрхлэгч, захирлын талаарх сэтгэл ханамжийн байдлын цахим судалгаа | |
| Сургууль(цэцэрлэг)-ийн удирдах хороо | Сургууль(цэцэрлэг)-ийн сурган хүмүүжүүлэгч болон эцэг эхийн төлөөллөөс бүрддэг бөгөөд гол чухал сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвшилцөж, зөвлөгөө өгдөг хороо | |
| Долоо хоног | Даваа гаригаас Ням гариг хүртэл нэг долоо хоногийн хугацаа | |
| Хичээлийн улирал | Нэг хичээлийн жилийг сургалтын үйл ажиллагааны хэрэгцээнд нийцүүлэн хуваасан хугацаа. Ихэвчлэн 3-8-р сар, 9-2-р сар гэсэн хоёр улиралд хуваагддаг | |
| Шилжин сурах | Сурч байгаа сургуулиасаа өөр сургууль руу шилжиж очоод суралцах | |
| Сургууль(цэцэрлэг)-ийн амьдралын тэмдэглэл | Сурагч(бага насны хүүхэд)-ын сургууль(цэцэрлэг)-ийн амьдралын төрх, бие бялдар, оюун ухаан, сэтгэл бодол, нийгэмч талаараа хөгжиж буй байдлыг нь тасралтгүй тэмдэглэсэн бичиг | Цэцэрлэгийг оруулаад |
| Ирсэнд тооцох таслалт | Гэр бүлийн гэрлэлт, нас баралт, хуулинд заасан халдварт өвчин, гэр бүлийнхэнтэйгээ туршлага судлах сургалтад хамрагдах гэх мэт шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд ирсэнд тооцох | |
| Долоо хоног тутмын сургалтын танилцуулга | Долоо хоногийн цагийн хуваарь, бэлтгэх зүйл, ангийн арга хэмжээ, ангийн багшийн хэлсэн зүйлс бүхий танилцуулга | |
| Хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрөл | Сургууль(цэцэрлэг)-ийн сургалтын үйл ажиллагаанд сурагч(бага насны хүүхэд)-ын хувийн мэдээллийг ашиглах талаар эцэг эхээс нь зөвшөөрөл авах бичиг | |
| Бие бялдрын хөгжлийн судалгаа | Сурагчийн өндөр, жин зэргийг хэмжиж бие бялдрын хөгжил, эрүүл мэндийг нь шалгах судалгаа | |
| Сурагчдын тайлан тоглолт | Сургууль(цэцэрлэг) дээр үзэсгэлэн, нээлттэй цуглаан, урлагийн үзлэг зэргийг зохион байгуулдаг сургалтын арга хэмжээ | |
| Хаалтын ёслол | Сургууль(цэцэрлэг)-т нэг жил сураад төгсөх арга хэмжээ | |
| Хичээл | Сургуульд заадаг хичээлүүд | |
| Сурах бичиг | Хичээл бүрийг сурах зорилгоор сурах бичиг болгон хийсэн ном | |
| Гүйцэтгэлийн үнэлгээ | Сурагч мэдлэг, ур чадвар, хандлага зэргийг эзэмшсэн эсэхийг шалгахын тулд түүний хийсэн бүтээл, гүйцэтгэсэн даалгаврыг янз бүрийн арга(эссэ, ярилцлага, хэлэлцүүлэг, туршилт, дадлага, ажиглалт, өөртөө тавих үнэлгээ, үе тэнгийнхний үнэлгээ гэх мэт)-аар үнэлдэг арга маяг | |
| Бүтээлч турших үйл ажиллагаа | Сургалтын хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаа бөгөөд бие даасан, бүлгэмийн, сайн дурын, мэргэжил сонгох арга хэмжээ гэсэн дөрвөн хэсгээс бүрддэг | Цэцэрлэгийг оруулаагүй |
| Өөрөө чиглүүлэх сургалт | Суралцагч сургалтад оролцох эсэхээ шийдэх, суралцах зорилгоо тодорхойлох, сургалтын хөтөлбөрөө сонгох, сургалтын үр дүнг үнэлэх зэрэг сургалтын бүх үйл явцыг өөрийн хүслийн дагуу сонгож, шийддэг сургалтын хэлбэр | |
| Сурагчдын зөвлөл | Нийт сурагчдын төлөөлөл болсон сурагчид цуглаад сургуулийн амьдралтай холбоотой санал бодлыг цуглуулж, хэлэлцэн шийдвэрлэж хэрэгжүүлдэг бие даасан бүтэц | |
| Сайн дурын үйл ажиллагаа | Сурагч хувиараа юмуу сургууль хамт олноороо нийгэм, олон нийтийн сайн сайхны төлөө сайн дураараа үйлчлэх | |



Хавсралт 1

Сургууль(цэцэрлэг)-ийн амьдралтай холбоотой нэр томьёо

| Нэр томьёо | Гол агуулга | Тайлбар |
|--|--|------------------------|
| Мэдэгдэл | Ангийн багшийн дамжуулдаг сургууль, ангийн мэдээллийг дэвтэрт бичиж, эцэг эхчүүд рүү илгээх | |
| Ангийн хариуцлагатай үүрэгтний сонгууль | Анги бүр санал хураалтаар ангийг төлөөлөх сурагч(тэргүүн, дэд тэргүүн)-ийг сонгох арга хэмжээ | |
| Танин мэдэхүйн аялал | Суралцагчдад байгаль, соёлыг үзэж, мэдрэх туршлага олгох зорилгоор ангийн багштайгаа хамт явах хонох аялал | |
| Долоо хоногийн ээлжийн ажил(ангийн туслах) | Ангийн гишүүдийн тогтоосон өдөр ангидаа сайн дураараа үйлчилдэг хүн | Цэцэрлэгийг оруулаагүй |
| Ангийн хурал | Сургуулиас тогтоосон тогтмол цагт ангийн гишүүдийн хийдэг хурал | |
| Номын сангийн үнэмлэх | Сургуулийн номын сангаас ном зээлэхэд ашигладаг номын сангийн үнэмлэх | |
| Сургууль хариуцсан цагдаа | Сургуулийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагч, эцэг эхчүүдэд урьдчилан сэргийлэх сургалт олгож, сургуулийн хүчирхийллийг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх үүрэгтэй цагдаа | |



Цэцэрлэгийн амьдрал

| Нэр томьёо | Гол агуулга |
|---|--|
| Бага насны хүүхэд | Цэцэрлэгт явдаг 3 наснаас эхлээд сургуулийн өмнөх нас(ихэвчлэн 5 настай)-ны хүүхдүүд |
| Цэцэрлэгт явах | Бага насны хүүхэд цэцэрлэгт явж, сурч эхлэх |
| Цэцэрлэгээс ирэх | Бага насны хүүхэд цэцэрлэгийн хүмүүжлийн үйл ажиллагааг дуусгаад гэртээ буцаж ирэх |
| Тоглох | Бага насны хүүхдийн дур сонирхолд нийцүүлэн цэцэрлэгийн дотор, гадна чөлөөтэй явагддаг үйл ажиллагаа |
| Өглөө, орой, бүтэн өдрийн асрамж | Эцэг эх нь хоёулаа ажилладаг юмуу өрх толгойлсон гэр бүлийн асран халамжлах шаардлагатай бага насны хүүхдүүдийг хичээлээс гадуур хөтөлбөрийн үеэр өглөө оройн цаг хүртэл асран халамжлах үйл ажиллагаанд хамаарах нэр томьёо (цэцэрлэгээс хамаарч цаг нь өөр өөр байж болно) |
| Цэцэрлэгийн захирал | Цэцэрлэгийн үйл ажиллагааг ерөнхийд нь удирдаж, хариуцдаг ажилтан |
| Цэцэрлэгийн орлогч захирал | Цэцэрлэгийн үйл ажиллагаанд захиралд тусалж, ажлыг нь дэмжин ажилладаг ажилтан |
| Төгсөлтийн ёслол | Цэцэрлэгийн нэг хичээлийн жилийн үйл ажиллагааг дуусгах арга хэмжээ |
| Цэцэрлэгийн зардал | Бага насны хүүхдийн сургалтад зориулсан сургалтын төлбөр гэх мэтийн сургалтын зардал болон бусад төлбөр |
| Бага насны хүүхдийн элсэлт | Өргөдөл, сугалаа, бүртгэл гэх зэрэг бага насны хүүхэд цэцэрлэгт орохын тулд дамждаг үйл явц |
| Танилцуулах өдөрлөг | (Танилцуулах өдөрлөг) Шинэ сурагчдын эцэг эхчүүдэд цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, арга хэмжээ зэргийг танилцуулах өдөр |
| Бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг | 4-60 сартай нярай болон бага насны хүүхдийн биеийн байдлыг шалгадаг эрүүл мэндийн үзлэг |
| Тусгай хөтөлбөр | Суралцагчийн зардлаар явагддаг хичээлээс гадуур хөтөлбөрт гадны багш нарыг урьж заалгадаг хөтөлбөр |



Бага сургуулийн амьдрал

| Нэр томьёо | Гол агуулга |
|---|--|
| Сурлагын хүснэгт | Сурагчийн сургуулийн амьдралтай холбоотой бүх асуудал(ирц, хичээлийн ахиц гэх мэт)-ыг тэмдэглэсэн материал бөгөөд улирлын төгсгөлд тараана |
| Эрүүл мэндийн үзлэг | Сургуулиас заасан эмнэлэгт 1, 4-р ангийн сурагчдын эрүүл мэндийг шинжилж, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг хийнэ |
| Амны үзлэг | Сургуулиас заасан шүдний эмнэлэгт 2, 3, 5, 6-р ангийн сурагчдын шүдний байдлыг шинжилж, урьдчилан сэргийлэх үзлэг хийнэ |
| Сургуулийн хариуцлагатан хүүхдийг сонгох сонгууль | Сургууль бүрийн сурагчид сургуулиа төлөөлөх сурагч(сургуулийн тэргүүн, дэд тэргүүн)-ыг санал хураалтаар сонгодог арга хэмжээ |
| Байгальд амарч сургах арга хэмжээ | Уул, далай гэх мэт байгальд сурагчийн зан чанар, оюун ухаан, бие махбодийг хөгжүүлэх гадуур арга хэмжээ |



Дунд, ахлах сургуулийн амьдрал

| Нэр томьёо | Гол агуулга |
|--------------------------------------|---|
| Хувийн хэрэг | Сургуулийн амьдралын ерөнхий оноо(сургуулийн шалгалтын оноо, гүйцэтгэлийн үнэлгээ, цаасан дээрх үнэлгээ гэх мэт) |
| Практик | Дүрслэх урлаг, хөгжим, биеийн тамир зэрэг хичээлийн шалгалтаар сэдэв бүрт тохируулан авах зураг зурах, хөгжим тоглох, холын харайлт харайх, гүйх зэрэг шалгалтыг хэлнэ |
| Англи хэлний сонсох чадварын үнэлгээ | Улсын хэмжээнд 17 хот, аймгийн Боловсролын газар хамтран удирдаж явуулдаг англи хэлний сонсох чадварын шалгалт. Жилд хоёр удаа явагддаг бөгөөд англи хэлний тэнхимийн гүйцэтгэлийн үнэлгээнд тусгагдах нь ч бий |
| Явцын шалгалт | Хичээлийн улирлын дундуур явагддаг сургуулийн шалгалт |
| Улирлын эцсийн шалгалт | Хичээлийн улирлын төгсгөлд явагддаг сургуулийн шалгалт |
| Туршилтын шалгалт | Хувийн хэрэгт дүн нь орохгүй ч их сургуулийн элсэлтийн шалгалтад бэлтгэн урьдчилж өгдөг шалгалт |
| Албан ёсны шалгалт | Их сургуулийн элсэлтийн шалгалтын дүнгээр үнэлдэг элсэлтийн сонгон шалгаруулалт |
| Урьдчилсан шалгалт | Ахлах сургуулийн хувийн хэрэг болон сургуулийн амьдралын бүхий л явц зэргийг голлон үнэлдэг их сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалт |
| Бүлгэм (С.А) | (С.А. : Club Activity) Нийтлэг хобби, сонирхол бүхий сурагчид сургуулиас тогтоосон албан ёсны цагт цуглаад явуулдаг арга хэмжээ |
| Бие даасан бүлгэм | Нийтлэг хобби, сонирхол бүхий сурагчид сургуулиас тогтоосон албан ёсны цагт бие даан цуглаад явуулдаг арга хэмжээ |
| Хөдөлгөөнт хичээл | Өөрийн ангийн кабинет бус тусгай кабинет(дүрслэх урлаг, англи хэл, шинжлэх ухаан гэх мэт) руу очиж хийдэг хичээл |
| Чөлөөт улирлын систем | Дунд сургуулийн сурагчид явцын болон улирлын эцсийн шалгалт өгөхийн оронд хэлэлцүүлэг, практик хичээл, ажлын дадлага хийх зэрэг мэргэжил сонгох сургалтад хамрагдах систем |
| Сургуулийн хүчирхийлэл | Сургуулийн дотор болон гадна нэг хичээлийн улирал юмуу хоёр хичээлийн улирлын хугацаанд сурагчдын өртсөн гэмтээх, хүчирхийлэх, цагдан хорих, айлган сүрдүүлэх, дээрэмдэх, залилах, нэр хүндэд халдах, доромжлох, заналхийлэх, хүчээр албадан зарах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, шоовдорлох, кибер аргаар бөөрөлхөх, мэдээлэл харилцааны сүлжээгээр садар самуун хүчирхийллийн мэдээлэл зэргийн улмаас бие махбод, оюун санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан үйлдэл |



Хавсралт 2

“Солонгосын боловсролын систем, дэвшин суралцах мэдээлэл” Эцэг эхчүүдэд зориулсан видео материал



“Солонгосын боловсролын систем ба дэвшин суралцах мэдээлэл” видеог сургуулийн өмнөх насны, бага болон дунд ангид сурдаг хүүхэдтэй хос соёлт гэр бүлийн эцэг эхчүүдэд сургуулийн мэдээллийг хялбархан ойлгоход нь тус дэм болох зорилгоор нийт 6 хэсэг хичээл(нэг хэсэг нь 20 минут орчим)-тэйгээр бэлтгэсэн.



Солонгосын боловсролын систем болон бага ангид орохоос эхлээд төгсөх хүртэлх сургуулийн амьдралын талаарх мэдээллийг хүргэж байгаа бөгөөд Хос соёлт боловсролын портал (edu4mc.or.kr), Прайм коллежийн насан туршийн боловсролын цөм хөтөлбөр(hub.knou.ac.kr), Хос соёлт гэр бүлийг дэмжих портал Данури (liveinkorea.kr) цахим хуудсаар вэбсайтаар дамжуулан хүсэлт гаргах боломжтой.



Солонгос хэлээр дуу оруулсан бөгөөд 5 хэл(орос, вьетнам, англи, япон, хятад)-ний хадмал орчуулгаас сонгох боломжтой.



Бага сургууль

Гол түлхүүр үг

| | | |
|----|---|---|
| 01 | Солонгос сургуулийн талаар мэдэж авах уу? | Ясли, цэцэрлэг, бага дунд ахлах сургууль, их дээд сургуулийн боловсролын байгууллага, ерөнхий боловсрол |
| 02 | Бага сургуульд орохдоо хэрхэн бэлдэх вэ? | Сургуульд элсүүлэх бичиг, урьдчилан цугларах өдөр, асрамжийн анги, хичээлээс гадуур хөтөлбөр, гэр бүлтэй харилцах захидал |
| 03 | Бага сургуулийн өдөр тутмын хөтөлбөр, жилд явагдах хөтөлбөрүүдийн талаар мэдэж авах уу? | Гол арга хэмжээ, хичээлийн сэдэв, хичээлийн цаг, үдийн хоол, газар дээр нь очиж туршлага судлах сургалт, зуны амралт, биеийн тамирын өдөрлөг, богино хугацааны амралт |
| 04 | Хүүхдийнхээ бага сургуулийн амьдралыг хэрхэн чиглүүлэх вэ? | Амьдралын удирдамж, шаардлагатай хичээлийн хэрэгсэл, зарлалын самбар, сургууль руугаа аюулгүй зорчих, ослоос урьдчилан сэргийлэх |
| 05 | Хүүхдийнхээ гэрийн даалгавар, хичээлийг хэрхэн чиглүүлэх ёстой вэ? | Сурах удирдамж, гэрийн даалгавар, цээж бичлэг, өдрийн тэмдэглэл, ном унших, гүйцэтгэлийн үнэлгээ |
| 06 | Бага сургуулиа төгссөөд яах вэ? (Хүүхдийн мэргэжил сонгож анги дэвших мэдээлэл) | Бага сургууль төгссөний дараах хичээлүүд, сонирхолд нийцэх чанар, анги дэвших, мэргэжил сонгох, ажил мэргэжил, гэрчилгээ, олж авах мэдээлэл |



Дунд сургууль

| | | | |
|----|---|----|---|
| 01 | Солонгосын дунд сургуулийн талаар мэдэж авах уу? | 02 | Дунд сургуулийн өдөр тутмын хөтөлбөр, жилд явагдах хөтөлбөрүүдийн талаар мэдэж авах уу? |
| 03 | Шилжилтийн насны хүүхдийнхээ амьдралыг хэрхэн чиглүүлэх вэ? | 04 | Хүүхдийнхээ хичээлийг хэрхэн чиглүүлэх ёстой вэ? |
| 05 | Чөлөөт улирлын систем гэж юу вэ? | 06 | Хүүхэд маань ахлах сургуульд орлоо. |



PM2022-60

**Хос соёлт сурагчдын эцэг эхчүүдэд
зориулсан элсэлтийн гарын авлага**

Хүүхдээ сургуульд явуулах

| | |
|--|---|
| Хэвлэсэн өдөр | 2022 оны 9-р сар |
| Эрхлэн гаргагч | Захирал Кан Дэжүн |
| Хэвлэсэн байгууллага | Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн |
| Хянан тохиолдуулсан гишүүд | Ким Гүйхён(Чунчонбүкдогийн боловсролын газар) На Эранн(Куанжү хотын боловсролын газар) Ан Соён(Ёоүл Нүри цэцэрлэг) |
| Судалгааны хамтын ажиллагааны байгууллага | Юүнь Ижи(Боловсролын яам), Чү Ёнжү(Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн) |
| Хаяг | Сөүл хот, Чүн-гү дүүрэг, Чонгэчонь-ру 14, Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн 9 давхар (Шуудангийн код) 04520 |
| Утас | 02-3780-9834 |
| Факс | 02-3780-9939 |
| Цахим хуудас | Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн (www.nile.or.kr) Хос соёлт боловсролын төв (www.edu4mc.or.kr) |
| Дизайн, орчуулга | “Дабл Нью Компани” ХК |

* Энэхүү материалын зохиогчийн эрхийг Боловсролын яам, Насан туршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн болон итгэмжлэгдсэн зохион байгуулагч байгууллага болох 17 хот/аймгийн Боловсролын газар эзэмшинэ.

* Энэхүү материалын зарим юмуу бүх хэсгийг зөвшөөрөлгүй иш татаж хэсэглэн авах, хуулбарлахыг хориглоно.